



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.09.25 № А-1/3688
танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх
тухай

Тус газраас зарласан ЭЗХЯ/20240103106 дугаартай "Хавдар судлалын үндэсний төв-II цогцолбор барилгын зураг төсөл/Улаанбаатар, Баянзүрх дүүрэг" төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

№	Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
1	Ижил төстэй ажлын туршлагаар орон сууц, олон нийтийн барилгын зураг төсөл гүйцэтгэсэн ажлын туршлагыг тооцох уу эсхүл зөвхөн эмнэлгийн зураг төсөл гүйцэтгэсэн ажлыг тооцох эсэх.	Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан "Барилга, хот байгуулалтын яамны: ЗТ-4.1. Өндөр төвөгшилтэй бүх төрлийн барилга байгууламжийн архитектур, барилга бүтээцийн зураг төсөл" тусгай зөвшөөрлийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлыг тооцно. Тус тусгай зөвшөөрлийн хүрээнд 30-51 метр өндөртэй 9-16 давхар орон сууцны өндөр барилга, 30-50 метр өндөртэй 9-16 давхар орон сууцнаас бусад зориулалттай өндөр барилгууд, 100 ба түүнээс дээш ортой нэгдсэн эмнэлэг буюу түүнтэй адил эмнэлэг, халдварт өвчин судлалын төв, цус бэлтгэх төв, зоонозын өвчин судлалын төв гэх мэт тусгай нөхцөл шаардах барилгуудыг өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн ангилалд тооцно гэж заасан байдаг.
2	Зөвлөх архитектор, зөвлөх инженер нь "Барилгын хөгжлийн төв"-д орон тооны бус эксперт хийдэг ба ТШЗ 19.2-т заасны дагуу "Барилгын хөгжлийн төв"-с холбогдох инженерүүд нь орон тооны бус экспертээр ажилладаг ба үндсэн ажилтан биш болохыг тодорхойлсон тухай албан бичгийг ирүүлсэн тохиолдолд тус заалтын нотлох баримтыг хангасанд тооцох уу.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу үнэлгээг хийнэ. ТШЗ 19.2-т заасны дагуу "Барилга хөгжлийн төв"-өөс ТӨҮГ-т ажилладаг бол давхар ажил эрхлэх зөвшөөрлийг эрх бүхий албан тушаалтнаас бичгээр авч ирүүлсэн байна.

ДАРГА

Ц.БАТЗУЛ